



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/117/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
Bayankhongor@audit.gov.mn  
Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70444470 Цахим хаяг:

Аудитор: Б.Бямбаа

Утас: 88050763 Цахим хаяг: Cpa\_baymba@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал .....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15

Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

34101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐᠒᠐.᠐᠔.᠒7 № 1/215

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

ЖИНСТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ М.БИБИШ  
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

᠐:᠕бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

0050᠒᠐᠒᠐᠐

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал М.Бибиш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.18-наас 2020.02.27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Хонгорын үр сад аудит ХХК-ны аудитор Ж.Байгалмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хонгорын үр сад аудит ХХК-ны газарт 2019.12.11-ны өдрийн 174 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Суралцахуйн чадварыг бүрэн эзэмшиж, зөв сайхан бичигтэй, эрүүл шүдтэй, мэндлэх, хүндлэх ёсонд төлөвшсөн сурагчидтай, бүтээлч хариуцлагатай хамт олонтой сургууль болно" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Аcolouc программ хангамж ашигладаг байна.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "Их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 673968,1 мянган төгрөгөөс тооцон 13479,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 13479,3 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## **2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос -118470,1 мянган төгрөгөөр буюу 0,73%-иар хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл -199533,1 мянган төгрөгөөр тус тус буурсан, бараа материалын дансны үлдэгдэл 1618,6 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,00	0,00	
Авлага	0	1618,6	1618,6
Урьдчилгаа	0,00	0,00	0,00
Бараа материал	25388,5	42616,4	17227,9
Үндсэн хөрөнгө	610959,9	411426,8	-199533,1
Хуримтлагдсан элэгдэл	-186882,5	-124666,1	-62216,4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>449465,9</b>	<b>330995,8</b>	<b>-118470,1</b>
Өр төлбөр	0,00	58,2	58,2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	449465,9	330937,6	-118528,3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>449465,9</b>	<b>330995,8</b>	<b>-118470,1</b>

Үндсэн хөрөнгийн 43752,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь төсвийн хөрөнгөөр 43752,5 мянган төгрөгийн хөрөнгө авсныг орлогод бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17227,9 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал 4658,1 мянга, тусгай зориулалтын материал 17704,5 мянга, аж ахуйн материал нэмэгдсэн ба харин мал амьтад дансанд бүртгэлтэй 7550,0 мянган төгрөгийг хасагдсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Жинст сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019.02.25-ны өдрийн 04 тоот тогтоолоор ашиглалтын шаардлага хангахгүй болсон 241285,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх онд байхгүй, тайлант хугацаанд нэмж өр үүсээгүй, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх .12 хөтөлбөрт зориулан 530519.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 530519.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан ба үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 19146,4 мянган төгрөг батлагдаж 16146,4 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нийт зардлын 472074,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 67430,7 мянга, нэмэлт санхүүжилтаар 3237,2 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 520539,2 мянган төгрөг буюу 96,4 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 18966,2 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс, халаалтын зардлын хэмнэгдсэн төсвийн 8063,5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, үдийн цай хөтөлбөрийн хэмнэлт 3,0 сая, цалингийн зардал 1720,5 мянга, НДШ-ийн зардал 5291,7 мянга төгрөгийн зарцуулаагүй үлдэглийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 3237,3 мянган төгрөг дансанд орсныг олгосон байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 10656,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 10656,7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, бэлэн мөнгөний тайлан гаргахгүйгээр зарцуулсан 10070,8 биет бус хөрөнгийн ашиглалтыг сайжруулахтай холбоотой 765,0 мянган төгрөгийн зөрчилд 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 10656,7 мянган төгрөгийн залруулагдаагүй 2 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлтээр худалдан авалт хийж тайлант хугацааны эцэст 5661,8 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул орон нутгийн төсөвт төвлөрүүлэв.

2. Цалингийн зардлаас байгууллагын багш, ажилтан нарт даргын 2019.11.10-ны өдрийн 110 тоот тушаалаар 3120,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт”-ын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн тул акт тогтоов.

3. Цалингийн зардлаас үдийн цайны зардалд тайлант хугацааны эцэст 1500,0 мянган төгрөгийн хүнсний материал бэлтгэн үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт”-ын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн байна.

4. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас хөөн давтан тооцоолоход төсвийн менежерийн 2019 оны 06 сарын 12-ны өдрийн Б/61 тоот тушаалаар цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан Ч.Эрдэнэсүрэнд 470.8 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.3. “ Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар бэлэн мөнгөний тайлан болон биет бус хөрөнгийн ашиглалттай холбоотой зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан бараа материал бусад зардлын мөнгийг нярвын хувийн харилцах данснаар дамжуулан худалдан авалт хийж байгаа зөрчлийг давтан гаргасан эсэхэд анхааралаа хандуулах.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6		5
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	73	23	
	Нийт	27	151	117	29	5

Улирал бүр мэдээлдэг төсвийн гүйцэтгэлийн мэдээний 3 дугаар улирлын мэдээ, тухай бүр мэдээлэх "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт"-ийн 8 дугаар сарын мэдээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах заасан мэдэгдлийн 8 дугаар сарын мэдээ зэрэг эдгээр 3 мэдээг хоцроосон байна. Мөн тухай бүр мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг-ийн 1-9 дүгээр сарын мэдээ мэдээллийг 2,3,4,8 дугаар мэдээг 10 сард нэмэлт зааварчилгаа өгсний улмаа дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас хоцроосон байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Биет бус хөрөнгө данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Тус байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгүүдийн ашиглалтын байдлыг судалж үзэхэд 200,0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ цахим архивд шилжсэнээр 565,0 мянган төгрөгийн бүртгэлтэй цалингийн программ ашиглалтгүй байна.

#### 1.2. Эрсдэл:

Хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиггүй зарцуулах

#### 1.3. Өгсөн зөвлөмж:

Дансанд бүртгэлтэй биет бус хөрөнгийг ашиглаж болох эсэхийг бусад эрх бүхий байгууллагад хандан дүгнэлт гаргуулж арга хэмжээ авч ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн хэрэгжүүлж ажиллана.

### **2. Мөнгөн хөрөнгө данстай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Тус байгууллагын Нярав Эрдэнэсүрэнгийн хувийн харилцах дансанд бараа материал, бусад зардлын нийт 10070.8 мянган төгрөг шилжүүлснийг бэлнээр авч зарцуулсан боловч кассын тайлан гаргаагүй ба мөн Ебаримт байгууллагуудаас авахгүй гүйлгээ хийсэн зөрчил илэрлээ.

2.2. Эрсдэл: Хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиггүй зарцуулах

#### 2.3 Өгсөн зөвлөмж:

Бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгж, иргэнээс худалдан авсан бараа материал бусад зардлын мөнгийг няравын хувийн харилцах данснаар дамжуулан худалдан авалт хийж байгаа зөрчлийг арилгаж, бэлэн мөнгө гаргасан тохиолдолд кассын тайлан гаргаж, бусад тохиолдолд харилцагчид шилжүүлэн холбогдох татвар, шимтгэлийг суутган тооцож тайланг гаргаж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрсөн хэрэгжүүлж ажиллана.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,388,540.00	44,235,148.09
33	АВЛАГА	00.00	1,618,698.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	1,618,698.09
35	БАРАА МАТЕРИАЛ	25,388,540.00	42,616,450.00
351	Түүхий эд материал	15,334,800.00	33,039,300.00
35110	Тусгай зориулалттай материал	15,334,800.00	33,039,300.00
354	Хангамжийн материал	2,503,740.00	9,577,150.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	808,000.00
35420	Аж ахуйн материал	00.00	1,607,400.00
35460	Хүнсний материал	2,503,740.00	7,161,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	424,077,384.90	286,760,701.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	424,077,384.90	286,760,701.06
392	Биет хөрөнгө	390,958,551.50	253,684,242.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	317,368,347.39	200,429,815.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,170,486.96	-33,688,291.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,528,569.52	94,383,846.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,868,194.27	-57,483,501.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,633,175.65	82,042,207.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,349,687.03	-32,957,834.55
39217	Ном	11,816,827.20	958,000.00
393	Биет бус хөрөнгө	33,118,833.40	33,076,458.43
39301	Програм хангамж	965,000.00	965,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-494,166.60	-536,541.57
39303	Бусад биет бус хөрөнгө	32,648,000.00	32,648,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	449,465,924.90	330,995,849.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	58,277.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	58,277.00
413	Өглөг	00.00	58,277.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	58,277.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	449,465,924.90	330,937,572.15
51	Засгийн газрын хувь оролцоо	449,465,924.90	330,937,572.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-197,469,902.56	-197,469,902.56
51101	Өмч: - төрийн	-197,469,902.56	-197,469,902.56
512	Хуримтлагдсан үр дүн	419,793,425.59	346,534,777.97
51210	Өмнөх үеийн үр дүн	419,793,425.59	465,004,853.72
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-118,470,075.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	227,142,401.87	181,872,696.74

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	449,465,924.90	330,995,849.15
---	--	----------------	----------------

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	419,690,456.00	559,530,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,265,500.00	16,787,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,265,500.00	16,787,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,265,500.00	16,787,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,265,500.00	16,787,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,888,556.00	70,667,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	408,536,400.00	472,074,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,237,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,237,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	67,430,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	67,430,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	426,256,438.60	546,647,807.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,256,438.60	546,647,807.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,353,426.60	520,601,319.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,120,242.00	319,698,013.00
210101	Үндсэн цалин	251,120,242.00	301,249,669.00
210104	Урамшуулал	00.00	18,448,344.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,408,455.00	37,470,677.26
210201	Тэтгэврийн даатгал	30,408,455.00	37,470,677.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,092,087.00	52,977,118.00
210301	Гэрэл, цахилгаан	4,639,011.00	4,090,181.00
210302	Түлш, халаалт	57,966,076.00	48,266,937.00
210303	Цэвэр, бохир ус	487,000.00	620,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,223,540.00	7,842,806.00
210401	Бичиг хэрэг	758,640.00	1,473,640.00
210402	Тээвэр, шатахуун	1,884,860.00	2,885,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	283,040.00	1,476,666.00
210404	Ном, хэвлэл	195,000.00	299,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	102,000.00	1,603,000.00
2105	Нормативт зардал	20,941,980.00	34,336,890.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	396,300.00

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210502	Хоол, хүнс	20,583,480.00	33,494,590.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	298,500.00	446,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,494,500.00	3,392,000.00
210602	Тавилга	00.00	392,000.00
210604	Урсгал засвар	1,494,500.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	647,700.00	2,531,000.00
210701	Гадаад албан томилолт	476,000.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	171,700.00	2,489,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	885,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	485,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,424,922.60	61,467,815.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,170,000.00	12,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,645,500.00	1,351,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,609,422.60	47,716,715.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,903,012.00	26,046,487.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,741,186.00	7,080,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,435,200.00	3,237,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	3,843,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,063,582.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,063,582.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,902,705.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,902,705.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,565,982.60	12,882,392.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,675,141.95	131,352,468.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	131,352,468.12
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,675,141.95	-131,352,468.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,241,124.55	-118,470,075.75

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	416,424,956.00	542,742,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	415,424,956.00	542,742,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	408,536,400.00	472,074,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,237,200.00

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,237,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	67,430,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	67,430,700.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>416,424,956.00</b>	<b>542,742,700.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,424,956.00	542,742,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,994,374.00	504,392,812.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,669,813.00	315,967,957.35
210101	Үндсэн цалин	206,702,158.00	275,478,791.35
210102	Нэмэгдэл	27,375,251.00	15,300,547.00
210104	Урамшуулал	18,592,404.00	25,188,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,858,884.00	44,319,431.00
210201	Тэтгэврийн даатгал	25,408,301.00	27,256,429.10
210202	Тэтгэмжийн даатгал	686,300.00	7,655,861.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	742,696.00	2,133,407.00
210204	Ажилгүйдлийн даатгал	131,387.00	471,904.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,890,200.00	6,801,828.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,964,887.00	52,867,118.00
210301	Гэрэл, цахилгаан	4,419,011.00	3,527,500.00
210302	Түлш, халаалт	58,186,076.00	48,829,618.00
210303	Цэвэр, бохир ус	359,800.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,706,340.00	13,011,506.00
210401	Бичиг хэрэг	518,340.00	2,475,040.00
210402	Тээвэр, шатахуун	1,884,860.00	2,885,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	238,440.00	2,566,466.00
210404	Ном, хэвлэл	357,700.00	2,733,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	707,000.00	2,171,500.00
2105	Нормативт зардал	23,764,350.00	32,366,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	321,300.00
210502	Хоол, хүнс	22,581,550.00	24,710,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,122,800.00	7,334,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,230,400.00	27,894,500.00
210602	Тавилга	00.00	21,394,500.00
210604	Урсгал засвар	1,230,400.00	6,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	647,700.00	2,531,000.00
210702	Дотоод албан томилолт	647,700.00	2,531,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	202,400.00	1,037,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	202,400.00	637,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,949,600.00	14,397,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,578,400.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,371,200.00	6,397,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,430,582.00	38,349,887.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,268,756.00	19,383,600.00

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,945,000.00	11,997,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,435,200.00	3,237,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	4,149,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	8,063,582.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	8,063,582.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,902,705.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,902,705.65

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	387,145,425.59	106,956,837.10	-191,533,511.41	00.00	302,568,751.28
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,145,425.59	106,956,837.10	-191,533,511.41	00.00	302,568,751.28
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,545,131.59	00.00	14,545,131.59
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,469,902.56	227,142,401.87	419,793,425.59	00.00	449,465,924.90
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,469,902.56	227,142,401.87	419,793,425.59	00.00	449,465,924.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	45,211,428.12	00.00	45,269,705.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	197,469,902.56	227,142,401.87	465,004,853.71	00.00	494,735,630.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-45,269,705.13	00.00	00.00	-45,269,705.13
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-118,470,075.75	00.00	-118,470,075.75
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	197,469,902.56	181,872,696.74	346,534,777.96	00.00	330,937,572.44

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны
----------	-------------

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	539,505,500.00	520,539,212.35
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	539,505,500.00	520,539,212.35
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	520,359,100.00	504,392,812.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,688,500.00	315,967,957.35
210101	Үндсэн цалин	273,091,300.00	275,478,791.35
210102	Нэмэгдэл	17,966,400.00	15,300,547.00
210104	Урамшуулал	26,630,800.00	25,188,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,611,100.00	44,319,431.00
210201	Тэтгэврийн даатгал	38,357,700.00	27,256,429.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,813,700.00	7,655,861.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,250,600.00	2,133,407.00
210204	Ажилгүйдлийн даатгал	562,500.00	471,904.50
210205	Эрүүл мэндийн даатгал	5,626,600.00	6,801,828.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,930,700.00	52,867,118.00
210301	Гэрэл, цахилгаан	3,527,500.00	3,527,500.00
210302	Түлш, халаалт	56,893,200.00	48,829,618.00
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,017,400.00	13,011,506.00
210401	Бичиг хэрэг	2,476,200.00	2,475,040.00
210402	Тээвэр, шатахуун	2,885,000.00	2,885,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,566,800.00	2,566,466.00
210404	Ном, хэвлэл	2,737,800.00	2,733,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,171,600.00	2,171,500.00
2105	Нормативт зардал	32,367,400.00	32,366,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	321,300.00	321,300.00
210502	Хоол, хүнс	24,710,600.00	24,710,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,335,500.00	7,334,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,750,000.00	27,894,500.00
210602	Тавилга	22,250,000.00	21,394,500.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,559,400.00	2,531,000.00
210702	Дотоод албан томилолт	2,559,400.00	2,531,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,037,600.00	1,037,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	637,600.00	637,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14397000.00	14397000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,397,000.00	6,397,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19146400.00	16146400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,146,400.00	16,146,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,997,000.00	11,997,000.00

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,149,400.00	4,149,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>539,505,500.00</b>	<b>520,539,212.35</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>472,074,800.00</b>	<b>461,172,094.35</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,074,800.00	461,172,094.35
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>67,430,700.00</b>	<b>59,367,118.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	67,430,700.00	59,367,118.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>34.00</b>	<b>34.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>228.00</b>	<b>222.00</b>

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**


/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		3237200
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		3237200
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		3237200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3237200
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3237200
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**БЭЛТГЭСЭН: АУДИТОР**  **Б.БЯМБАА**

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**  **А.ЦЭЭНЯМ**

**ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**  
**ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**  **Б.МӨНХБАТ**

